



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/193

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.3“б” дэх заалт, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбай сонгох тухай” 118 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуучнаар Усны аж ахуйн байрны орчмын гэр хорооллын 6.64 га газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдуулан уг төлөвлөгөөнд хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн, хөндөгдөж болзошгүй иргэн, хуулийн этгээдийн саналыг авч тусгах, судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Сарангарав - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Намуун – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Мөнхсоёл - Баянхонгор сумын Засаг дарга

Ц.Мөнхжаргал - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Н.Мөнхбаатар – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн

А.Цэцэнбилэг – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн

Н.Зөөлөнцагаан - Номгон багийн Засаг дарга

Э.Цэрэндаваа - Номгон багийн нийгмийн ажилтан

Нарийн бичгийн дарга: С.Хүрэлхуяг - Аймгийн Ерөнхий архитектор

1210481

2.

2.Дахин төлөвлөлтөд орсон хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн, хөндөгдөж болзошгүй иргэн, хуулийн этгээдтэй уулзаж хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг авч Засаг даргын зөвлөлд 2021 оны 07 сарын 01-ний дотор танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН